

**УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2026 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2026 оны 06 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Хариуцсан албан тушаалтан, хамтран хэрэгшүүл эх байгууллаг а алба, тасаг, нэгж
1.	Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, үнэлгээ хийж олон нийтэд ил тод мэдээлнэ.	Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулсан тоо	Нээлттэй болгохоор хууль, журамд заасан мэдээллийг цахим системд байршуулсан байна	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8-р зүйлийн хэрэгжилтийг хангаж байгууллагын цахим хуудсанд 1 болон 2 улирлын нийт 12 тайлан төлөвлөгөөг оруулсан. Мөн 1 болон 2-р улирлын тайланд shilen index руу 86 мэдээ тайлан оруулсан мөн shilen dans тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж хагас жилийн байдлаар 77 мэдээлэл байршуулсан байна.	ЭБАТ Мэдээлэл технологийн алба
2.	Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх	Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор	Сурталчилгаа явуулсан байна.	- Авлигатай тэмцэх газрын албан ёсны хуудсанд	ЭБАТ Мэдээлэл

	суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар эрүүл мэндийн ажилтнуудад сурталчилна.	мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар сурталчилсан хэлбэр, тоо		байршигдсан мэдээг эмнэлгийн нийгмийн сүлжээнд /фейсбүүк/ байршуулсанБайгууллагын албан ёсны цахим хуудасны нүүр хэсэгт “Авлигын эсрэг үйл ажиллагаа цэстэй бөгөөд уг цэсэнд • Монгол Улсын Авлигын эсрэг хууль • Эрүүл мэндийн салбарын Авлигын эсрэг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө • Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх Газар Чиглэл хүргүүлэх тухай • Монгол Улсын авлигатай тэмцэх үйл ажиллагааны мэдээлэл зэргийг байршуулсан. - . Байгууллагын албан ёсны цахим хуудасны нүүр хэсэгт “Холбоос” хэсэгт Авилгатай тэмцэх газрын цахим хаяг, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн системрүү шууд хандах байдлаар холбосон. - Байгууллагын албан ёсны цахим хуудсаны нүүр хэсэгт “Видео мэдээ” хэсэгт Авилгатай тэмцэх газраас бэлтгэсэн шторкийг холбосон. - Авлигын эсрэг үйл ажиллагааг	технологийн алба
--	--	--	--	--	------------------

				мэдээлэн сурталчлах хүрээнд эмнэлгийн төв байр, оношилгооны төвийн байр, 50 ортын байр тус бүрд мэдээллийн самбарт, алба, төв, тасаг, нэгжүүдэд хүлээлгийн танхим, цахим бүртгэл, дүрс оношилгооны бүртгэлийн хэсэг гэх зэрэг нийтийн хэсгүүдэд сурталчилгааны материалуудыг байршуулсан.	
3.	Эмнэлгийн хэмжээнд сул орон тоонд хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалт зарлах, хууль бус “түр орлон гүйцэтгэгч” томилохыг зогсоох	Холбогдох хууль журмын дагуу хийсэн томилгооны тоо	Холбогдох хууль, журмын дагуу томилгоо хийсэн байна.	Улсын хоёрдугаар төв эмнэлгийн захирлын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/31 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн ажилтан сонгон шалгаруулж авах” журмын дагуу 2026 онд нийт 34 ажлын байранд давхардсан тоогоор 41 удаагийн ажлын байрны сонгон шалгаруулах зарыг SSCH.gov.mn веб сайт болон цахим орчинд нээлттэй зарлан бүх албан тушаалтныг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, олонхын саналаар сонгогдсон ажилтыг туршилтын 3 сарын хугацаагаар томилон ажиллуулж байна. Үүнээс: Эмч-11 Сувилагч-15 Дэмжих алба-13 Гэрээт-18 ажилтан шинээр туршилтын хугацаагаар албан тушаалд томилогдсон. Нийт 7 ажилтан туршилтын 3 сарын хугацаа нь дуусч, Удирлагын зөвлөлөийн	ЭБАТ Хүний нөөцийн алба

				хурлар хэлэлцэн жинхлэн томилогдмон байна.	
4.	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд бүрийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг АТГ- аар хянуулж, дүгнэлт гарсны дараа томилгоог баталгаажуулах	АТГ- ын хяналтад хамрагдсан томилгооны хувь	Тухай бүр АТГ- т ХАСУМ- ийг хянуулсан байна.	2026 оны хагас жилийн байдлаар нийтийн албад томилогдох 5 ажилтны ХАСУМ-ыг хянуулж, хариу албан бичиг ирсний дараа албан тушаалд томилох тушаал гарсан. Үүнд: албан тушаал дэвшин томилогдсон 2 (Амбулаторийн тасгийн эрхлэгч, Эм зүйн албаны дарга), шинээр томилогдсон 1 (Шуурхай удирдлагын төвийн эрхлэгч), түр орлон гйүцэтгэгчээр томилогдсон 2 байна.	Эмнэлгийн захирал ЭБАТ Хүний нөөцийн алба
5.	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд өөрийн болон хамаарал бүхий этгээдийн байгууллага руу өвчтөнийг чиглүүлэх үйл ажиллагаанд ёс зүйн хяналт тавих	Хяналт хийсэн тайлан	Хяналтаар гарсан зөрчлийг арилгасан байна.		ЭБАТ Хүний нөөцийн алба Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо
6.	Ажилчдын шагнал, урамшууллыг бэлнээр эргүүлэн татах, зориулалтын бусаар (ойн баяр гэх мэт) зарцуулахыг таслан зогсоох, санхүүгийн	Эрх бүхий байгууллагын дүгнэлтээр ирсэн санхүүгийн зөрчлийн дүгнэлт	Зөрчлийг бүрэн арилгасан байна.	Засгтийн газрын хяналт эрхлэг газар, ЭМЯ-ны хамтарсан шалгалт хийгдэж байна. Дүгнэлт гараагүй байна.	Дотоод хяналтын ажилтан

	дотоод хяналтыг сайжруулах				
7.	Байгууллагын удирдах ажилтан болон эмнэлгийн мэргэжилтнүүдэд Авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол сургалт зохион байгуулах	- Сургалтад хамрагдсан нийт ажилчдын эзлэх хувь - Зохион байгуулсан сургалтын тоо	- ЭМЯ- ний харьяа байгууллагууд улиралд 1 сургалт зохион байгуулсан байх - Ажилтнуудын оролцоо 90%- с дээш байх	Албан үүргээ гүйцэтгэсний дараа төлөө нэмэлт төлбөр, шууд болон шууд бусаар бэлэг, хандив, бусад санхүүгийн туслалцаа авах нь авлигын зөрчил болох талаар сургалт, нөлөөллийн арга хэмжээг тусгайлан зохион байгуулах ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Д.Балдандоржтой хамтран ажиллаж байна. Үүнд: 1. 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдөр худалдан авах үйл ажиллагаанд оролцдог АЗ гэрчилгээтэй эмнэлгийн ажилтнууд болон албадын дарга, тасгийн эрхлэгч нарт Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Д.Балдандорж “Авлигын хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчил” сэдвээр сургалт, хэлэлцүүлэг хийсэн. Сургалтад нийт 40 ажилтан хамрагдсан. 2. 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Авлигатай тэмцэх	ЭБАТ Хүний нөөцийн алба Сургалт гадаад харилцааны алба

				газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Д.Балдандорж нийт сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд “Авлигын хор хөнөөл” сэдвээр сургалт хийсэн. Сургалтад нийт 123 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан. 3. 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Zoom meeting хэлбэрээр АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар Ц.Баасандэлгэрийн хийсэн сургалтад ХАСХОМ мэдүүлдэг албан тушаалтнууд хамрагдсан 4. 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Д.Балдандорж 1800-0119 Дуудлагын төвийн ажилтнуудад “Авлигын хор хөнөөл”, “Эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах” гэсэн сэдвээр сургалт хийсэн. Сургалтад тус төвийн 18 ажилтан хамрагдсан.	
--	--	--	--	---	--

				Хавсралтаар зурган баримтжуулалт хавсаргав	
8.	Байгууллага бүр төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, тендерийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу цаг тухайд нь мэдээлэх	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээний хувь	Үнэлгээний хувь 95%- с дээш байх	Шилэн дансны тухай хуулпау дагуу 2026 оны 2-р улирлын байлдаар Шилэн дансанд ил тод мэдээллэх шаардлагатай төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагааны 82 мэдээ тайлан хугацаандаа оруулсан байна.	Маркетингийн менежер ЭБАТ Мэдээлэл технологийн алба
9.	Эрүүл мэндийн салбарын шударга байдлын үнэлгээг 2026 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөний хэрэгжилт 95%- с дээш байна.	Улсын хоёрдугаар төв эмнэлгийн шударга байдлын үнэлгээг 2026 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг ЭМЯ-аас ирүүлсэн загварын дагуу боловсруулан гаргаж Эмнэлгийг захирлаар батдлуулсан. Төлөвлөгөөнд 12 үйл ажиллагаа төлөвлөгдсөн. 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 70%-тай байна.	ЭБАТ Төлөвлөгөөнд тусгагдсан хариуцах эзэд
10.	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, дүгнэлтэд тусгагдсан зөрчлийг арилгах төлөвлөгөөг тухай бүр гарган, хэрэгжилтийг бүрэн хангаж, тайланг	Ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтийн дагуу арилгасан зөрчлийн тоо	Зөвлөмжөөр өгсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байх	Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсээс ирүүлсэн 9 зөвлөмжийн 2-ийг бүрэн хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн. Бусад 7 зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн ажлын тайланг дахин дэлгэрүүлэн бичиж илгээсэн.	Эмнэлгийн захирал ЭБАТ

	Авлигатай тэмцэх газар болон Эрүүл мэндийн яаманд хүргүүлэх				
11.	Эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлэгч төвтэй, хүндэтгэлтэй харилцаа, ёс зүйд суурилсан чанартай тусламж, үйлчилгээний соёлыг төлөвшүүлэх хүрээнд “Хүндэтгэлтэй харилцаа-Чанартай тусламж” аян зохион байгуулах	- Улирал бүр аян зохион байгуулсан харьяа байгууллагын тоо - Ажилтнуудын оролцооны хувь	- ЭМЯ- ний харьяа байгууллагууд улиралд 1 аян зохион байгуулсан байх - Ажилтнуудын оролцоо 90%- с дээш байх	УХТЭ-ийн Ёс Зүйн салбар хорооноос 2026 онд ажилтнуудад зориулан эмнэлгээр үйлчлүүлэгч иргэд болон эмнэлгийн ажилтан хоорондын харилцааны зөрчил болон холбогдох хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулах зорилгоор соён гэгээрүүлэх сургалтуудыг тасралтгүй хийж байгаа билээ. Энэхүү ажлын хүрээнд 2026 он гарсаар дараах сургалтуудыг хийгээд байна. Үүнд: 1. Эмнэлгийн ажилтнуудад зориулан ЭМС-ын 2019 оны 09 сарын 04-ний өдрийн А/406 дугаар тушаалыг бүрэн эхээр нь аудио болон РРТ хавсарсан цахим хичээл болгон бэлтгэж эмнэлгийн ажилчид хүссэн үедээ сонсох, үзэх боломжтой байдлаар дотоод сүлжээнд тогтмол байршуулсан. Энэ сургалтыг 2026 оны 03-р сарын 13-нд дотоод сүлжээнд оруулж, 6-р сарын 10- хүртэлх хугацаанд давхардсан тоогоор нийт 626 үзэлттэй байна.	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо ЭМТҮЧАБЭ-ийн алба

				2. 2026 оны 03-р сарын 17-нд УХТЭ-ийн резидент эмч нарт зориулан Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль А/174 тоот тушаал (2025 он), Нийтийн албанд нийтийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (Цахим орчин, ашиг сонирхлын зөрчил), Зөрчлийн тухай хууль, (Ёс зүйн алдаа гаргасан тохиолдолд хүлээлгэх захиргааны хариуцлага) зэрэг агуулгын хүрээнд “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” сэдвээр 1 удаа 45 минутын сургалт зохион байгуулсан. Уг сургалтад тус эмнэлэгт суралцаж байгаа 28 резидент эмч хамрагдсан. Сургалтыг Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны гишүүн их эмч Н.Түвшинбаяр удирдан зохион байгуулсан. 3. 2026 оны 04-р сарын 03-нд УХТЭ-ийн дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний “Ёс зүйн салбар хороо”-ны бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөө	
--	--	--	--	---	--

				болон ЭМС-ын 2025 оны А/174 тоот тушаал, Эмнэлгийн мэргэжилтний “Ёс зүйн хэм хэмжээ”- ний талаар шинэчлэгдсэн хуулийн заалтуудын тайлбар тохиолдол хэлэлцүүлэг агуулгын хүрээнд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос (гишүүн их эмч Д.Мөнхжаргал) УХТЭ-ийн нийт эмч нарт зориулан нэг удаагийн сургалт зохион байгуулсан. Уг сургалтад нийт 91 эмч оролцсон байна. 4. 2026 оны 04-р сарын 14-ны өдөр УХТЭ-ийн төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад элссэн эмч, сувилагч болон шинэ ажилтны чиглүүлэх сургалтад УХТЭ-ийн Ёс зүйн салбар хорооноос Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль А/174 тоот тушаал (2025 он), Нийтийн албанд нийтийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (Цахим орчин, ашиг	
--	--	--	--	--	--

				сонирхлын зөрчил), Зөрчлийн тухай хууль (Ёс зүйн алдаа гаргасан тохиолдолд хүлээлгэх захиргааны хариуцлага) зэрэг агуулгын хүрээнд 40 минутын онол ба тохиолдолд суурилсан хичээл бэлтгэн хүргэсэн. Энэ сургалтад нийт 82 хүн хамрагдсан. Хавсралтаар зурган баримтжуулалт хавсаргав.	
12.	Авлига, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах олон сувгийн (утас, цахим, саналын хайрцаг) тогтолцоог бүрдүүлж, мэдээлэгчийн нууцлалыг ханган, шуурхай шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах	- Ажиллаж буй гомдол хүлээн авах сувгийн тоо (утас, цахим, саналын хайрцаг гэх мэт) - Ирсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хувь	- Доод тал нь 2 төрлийн суваг тогтмол ажилладаг байх - Ирсэн гомдлын 90%- с дээш хувийг шийдвэрлэсэн байх	Өргөдөл гомдол, санал хүсэлтийг 70150206 , 70150205 утсаар, мөн 1111 төвөөр, эмнэлгийн цахим Info@www.sshc.gov.mn , веб хуудсаар (ssch.gov.mn), эмнэлгийн мэйл хаягаар иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авдаг. Түүнчлэн эмнэлгийн амбулаторийн хэсгүүдэд нийт 12 ширхэг санал хүсэлтийн хайрцаг байршуулсан. Үндэсний оношилгоо эмчилгээний төвийн 1 давхар, төв байрны 1 давхарт тус тус талархлын самбар ажиллуулсан. Хагас жилийн байдлаар нийт 137 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирсэн. Шийдвэрлэлт 98% Үүнэс авлига, ёс зүйн зөрчил бүртгэгдээгүй. Эмнэлгийн ажилтны харилцаа, хандлагатай холбоотой 7 гомдол	ЭБАТ ЭМТҮЧАБЭ-ийн алба

				ирснийг тухай бүрт шийдвэрлэсэн байна.	
--	--	--	--	---	--